



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/211

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 147 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэг, "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 2,736,000.0 /хоёр сая долоон зуун гучин зургаан мянга/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн 147 дугаар цэцэрлэг /Х.Чимэдцэрэн/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн 147 дугаар цэцэрлэг /Х.Чимэдцэрэн/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ




Ш.ҮНЭНБАТ

2019\Tushaal-1\8 cap.docx

115050000971

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2019 оны 09 сарын 07 өдрийн 177 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 147 дугаар цэцэрлэг

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан эзлэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭВХХК-ын шийдвэр
1	Хайс хашлага	28	м	114	24,000.00	2,736,000.00	2,736,000.00	-	Цашид ашиглагдахгүй, эвдрсэн.	татах
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн							2,736,000.00	2,736,000.00		
				114						
	Үүнээс: Хуудалдах хөрөнгө									
	Актулах хөрөнгө									
	Татан төвлөрүүлэх хөрөнгө					2,736,000.00				
	Хуудалданаас олох орлого									
	НӨАҮГ-т төвлөрүүлэх /30%/									

Барилга байгууламж